



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/102

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 23 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолын 06 дугаар хавсралт, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Төрийн албан хаагчдыг чадавхжуулах танхимын болон цахим сургалтын нэгдсэн арга хэмжээний зардалд 15,000,000 (арван таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын зардлын тооцоог нэгдүгээр хавсралтаар, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад үндэслэн "Танхимын болон цахим сургалт"-ын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж тухай бүр түвшинг тогтоох зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 22-ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Зардлын тооцоо

Д/д	Арга хэмжээ	Тоо	Мөнгөн дүн
1	Танхимын сургалтын зардал	3	6000000
2	Цахим сургалтын зардал	12	6000000
3	Эрх бүхий албан тушаалтны сургалтын зардал	1	3000000
	Дүн		15000000



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 22-ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ
ТАНХИМ БОЛОН ЦАХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

№	Агуулга	Хугацаа	Оролцогч
Цахим сургалт			
1	Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх, үйл ажиллагаанд хориглох зүйл, Ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг	III сар 07 16:00-17:00	Төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан хаагч
2	Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн төлбөр тусламж, Нийгмийн баталгаа, Цалин хөлс, олговор	III сар 21 16:00-17:00	
3	Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журам, Төрийн албан дахь хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, Хөдөлмөрийн гэрээ	IV сар 04 16:00-17:00	
4	Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүн	IV сар 18 16:00-17:00	
5	Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, Хөдөлмөрийн дотоод журам, хариуцлага	V сар 02 16:00-17:00	
6	Маргаан хянан шийдвэрлэх, хөдөлмөрийн маргаан	V сар 16 16:00-17:00	
7	Ес зүйн зарчим, ёс зүйн хариуцлага	IX сар 05 16:00-17:00	
8	Нийтийн мэдээлэл хариуцагч, мэдээлэл авах эрх	IX сар 19 16:00-17:00	
9	Төрийн цахим үйл ажиллагаа	X сар 03 16:00-17:00	
10	Өргөдөл гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, Өргөдөл гомдол гаргах, хүлээн авах шийдвэрлэх, хариу өгөх	X сар 17 16:00-17:00	
11	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	X сар 31 16:00-17:00	
12	Хориглох зүйл, албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт	XI сар 14 16:00-17:00	
Танхим сургалт			
13	Эрх бүхий албан тушаалны сургалт	2 дугаар улирал	Улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтнууд
14	Удирдах түвшний манлайлын сургалт	2 дугаар улирал	Агентлаг, байгууллагын удирдлага
15	Бодлого төлөвлөлтийн баримт бичгийн таницуулга сургалт	3 дугаар улирал	Байгууллагын хүний нөөцийн албан тушаалтнууд
16	Мэргэшүүлэх богино хугацааны сургалт	4 дүгээр улирал	Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтнууд